

МХЗЭ-ИЙН ТӨВ ХОРООНЫ ХАРЬЯА ХҮҮХЭД
ЗАЛУУЧУУДЫН НАЙРАМДАЛ ПАРКИЙН
ТАНИЛЦУУЛГА

1985. IV. 25.

Улаанбаатар хот

Хүүхэд залуучуудын "Найрамдал" парк анх 1966 онд байгуулагдсан цагаасаа МАХН, МХЗЭ-ийн байгууллагын анхаарал санаачилгаар зохион байгуулалт, санхүү аж ахуй, хөрөнгө хүчний талаар өсөн бэхжиж ирлээ.

"Найрамдал" парк 1978 онд МХЗЭ-ийн Төв Хороонд эргүүлэн харьяалагдсанаас хойш МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 278-р тогтоолыг биелүүлэх ажлыг эрчимтэй зохиож паркийн бүх барилга байгууламж, тоглоом төхөөрөмжид засвар хийж үйлчилгээний чадвараа жил тутам дээшлүүлсээр байна. Зөвхөн сүүлийн 3 жилд ЗХУ-аас 1,5 сая төгрөгийн үнэ бүхий 7 төрлийн аттракцион тоглоом тоног төхөөрөмжөөр тоноглогдон шинэчлэгдсэн байна.

"Найрамдал" парк одоо 10,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 30 гаруй төрлийн автомат болон аттракцион тоглоомуудтай юм. Хүүхдийн болон насанд хүрэгчдэд зориулсан "Алсыг харагч", "Ромашка", "Гэрлэн дохио", "Сюрприз", "Хөгжөөнт аялагч", "Уран жолоодлогын машин", "Цуужин", "Гинжит", "Морин цогио", "Буга" бусад дүрсийн тойруулгууд зэрэг аттракцион тоглоомуудаас гадна Зуны театр, бүжгийн талбай, кино театр, теерех байр, буудлагын клуб, завийн станц, инээдмийн толь, угсаатны зүйн музей, спортын тоглоомууд зэрэг 40 шахам төрлийн тоглоом үйлчилгээгээр жилдээ 1 сая гаруй хөдөлмөрчид, хүүхэд залуучуудад үйлчилдэг боллоо.

Түүнчлэн хүүхдийн хөдөлгөөнт автомат морь, онгоц, цуужин, завь, насанд хүрэгчдэд зориулалттай мэргэн буудагч, агаарын тулалдаан, анчин, тэнгэсийн тулалдаан зэрэг 10 гаруй төрлийн автомат тоглоом, үлгэрийн гэр байнга ажиллаж өвөл зуны улирлуудад тохируулан үйлчлэх цана, чарга, тэшүүр, теннис, бильярд ажиллуулахын зэрэгцээ бүх яам, тусгай газрын системийн ажилчдын өдөрлөг, уулзалт, биеийн тамир спортын уралдаан тэмцээн, социалист зан үйлийн ба тэмдэглэлт ойн баярууд зэрэг төрөл бүрийн

200 гаруй арга хэмжээнүүд явуулж байна. Бүх төрлийн тоглоом тоног төхөөрөмжийг засварлах үйлдвэрлэлийн цех, "Ундраа" хөгжмийн хамтлаг, зураачдын ажлын байр, зуны улиралд үйлчлүүлэгч, хөдөлмөрчид, хүүхэд залуучуудад хөнгөн зууш, ундаа хүнсний бараагаар үйлчлэх худалдааны яармаг ажилладаг юм.

Паркийн дотор 2*15 метрийн өндөр 10 гаруй мянган мод бут сөөгтэй бөгөөд зуны улиралд мод бут сөөг нь цэцэглэж ургаж, усан оргилуур ажиллан цэцгийн мандал, олон өнгийн цэцэг алаглан эрүүл тунгалаг агаар, цэвэр сайхан орчинд хол ойрын вочин гийчин, нийслэлийн хөдөлмөрчид, хүүхэд залуучууд байнга зугаалан амарч байна.

Тус парк үйлчилгээний ердийн өдөр 3000-5000 хүнд хагас бүтэн сайн өдрүүдэд 20,0-40,0 мянган хүнд баяр ёслолын зарим өдрүүдэд 60,0-70,0 мянга орчим хүнд үйлчилж байгаа үйлчилгээний том төв болж байна.

Хүүхэд залуучуудын "Найрамдал" парк нь 2276 метр хашаанд 40 шахам га талбайтай бөгөөд энэ талбайд зүлэг мод ургамалтай талбай 25 га, хатуу хүчилттай зам 1485 м, шороон ба хайрган зам 8020 м, цардмал талбай 2685 м², 6000 шахам метр усалгааны систем, гүний худаг 4, замын бетон хашлага 10253 м, 1215 м дулааны шугам, холбооны ил далд 3400 м шугам, гэрлийн шон 261, дотуур холбооны шугам 5000 м, радио трансляцийн шугам 2000 м, контор, аж ахуйн ба спортблок, музей, автомат тоглоом зэрэг 20 гаруй барилга байгууламж, хот нийтийн эд аж ахуйтай юм.

Өвөл зуны улиралд нийтдээ 100-150 ажиллагсадтай, үүний 12% нь харуул манаа, 55% нь үйлчлэгч, инженер техникийн ажилтан ажилчид ажиллаж байна.

Хүүхэд залуучуудын "Найрамдал" паркийн хамт олон МАХН, МХЗЭ-ийн ХҮШ их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх олон хэлбэрийн ажил зохиож 1984 онд Сүхбаатарын району соёлч байгууллага болж ҮШ таван жилийн эхнээс эхлэн жил бүр төлөвлөгөөт үзүү-

лэлтээ давуулан биелүүлж, одоо 1986 онд болох 20 жилийнхээ ойг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтах өрнүүн эрмэлзлэлтэй ажиллаж байна.

Паркийн ажилчдын дунд социалист уралдааныг оны эхнээс улирал бүрт тодорхой сэдвийн дор өрнүүлж, хүн бүр идэвх-санаачлагыг өндөр хариуцлага сахилга баттай холбон улсын төлөвлөгөөт даалгаврыг жигд биелүүлж, соёлч үйлчилгээтэй хоцрогсодгүй хамт олон болох зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Ажилчдын санаачлагаар чадах бүхнээрээ байгууллагадаа туслах, хамгийн сайхан мод цэцэгтэй болох, талбай бүр нь соёлжилт тохижилтын гэрчилгээтэй болох, өнгө будгаар тэргүүний байх гэх мэт хөдөлгөөн өрнөсөн нь манай хамт олны идэвх чармайлт өндөр байгаагийн баримт юм.

Тус байгууллагад 1984 оноос эхлэн залуучуудын гавшгай бригад нэг ажиллаж манай үндсэн гол аж ахуй болох ногоон байгууламжийн ажлыг сайжруулахыг гавшгай үйлсээ болгон хөдөлмөрлөж байна.

Ажилчдынхаа ажиллах нөхцөл ахуй хангамжийг сайжруулахын тулд 1984 оноос эхлэн урамшлын систем бий болгож ажилласны гадна ажлын байр, өрөө тасалгааг тэнд ажиллагсадын санаачлагаар сайжруулах ажил хийгдэж Байгалийн сурталчилгааны кабинет шинээр байгуулж хөгжимдийн өрөөг хамт олны нь хүчээр тохижуулж, ажилчдын цайны газар байгуулан ажиллуулж, багаж материалын болон хувцасны өрөөнүүдийг бүрэн сайжруулав.

Одоо манай хамт олон нийслэлийн хөдөлмөрчид хүүхэд залуучуудад үйлчлэх үйлчилгээний бэлтгэлээ 100% хангаж 5-р сарын 1-нээс ажиллахад бэлхэн болоод байна.

"НАЙРАМДАЛ" ПАРК

Анкет
Монголын Үндэсний Соёл Амралтын Хүрээлэнгийн
Анкетчилсан танилцуулга

- a) – **Овог нэр:** - Нийслэлийн засаг даргын харьяа, Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн
 - **Нас:** \ 32 \ 1966 оны 6 сард байгуулагдсан
 - **Үндсэн захиргаа:** - Сүхбаатар дүүргийн 1-р хороо
 - **Дэвсгэр нутаг** – 35 га галбайтай үүнээс 27 га талбай нь ногоон байгууламж, 1,8 га нуур, цөөрөм, 0,6 га нь зам талбай, 5,6 га нь тоглоом, тоног төхөөрөмж, соёл хүмүүжлийн ажлын төвүүдийн болон аж ахуйн зориулалттай барилгажсан талбай юм.
 - **Үйл ажилгааны зорилго нь:**
 - Нийслэлийн хөдөлмөрчид, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, Монгол ардын өв уламжлал, зан заншил, ёс зүйг залуу үедээ эзэмшүүлэхэд туслах явдал мөн.
 - **Үйлчилгээний чиглэл:**
 - a) Мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэгдсэн улс төр, үзэл суртал, соёл хүмүүжлийн олон талт ажлуудыг зохион байгуулана.
 - b) Худалдаа, нийтийн хоол, ахуйн бүх төрлийн үйлчилгээгээр соёлч, боловсон, хөнгөн шуурхай үйлчилнэ.
 - c) Хөгжөөнт болон хөдөлгөөнт цахим тоглоомуудаар үйлчилнэ
 - d) Мэргэжлийн өндөр түвшинд ардын язгуур урлагын тоглолтууд хийнэ.
 - e) Спортын бүх төрлийн уралдаан, тэмцээн, үзүүлэх тоглолтуудыг зохион байгуулна. \ Бага наадмууд \
 - f) Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, өвөл зуны спортын бэлтгэл сургуулилтыг хийнэ.
 - g) Гадаадын зочид төлөөлөгчид, жуулчидад үйлчилнэ.
 - h) Цэцэгжүүлэлт хийнэ. \ албан тасалгааны, боодлын, талбай \
 - i) Жолооч бэлтгэнэ. \ "В" ангилалын \
2. Материаллаг бааз \ хүчин чадал \
- a) Соёл, спортын цэг, нэгжүүд
 - Цэнгэлдэх хүрээлэн – 10,0 мянган хүний суудалтай
 - Зуны задгай театр – 2000 хүний суудалтай
 - Бүжгийн талбай – 200 хүний багтаамжтай
 - Үлгэрийн их өргөө - 150 хүний суудалтай
 - Угсаатны зүйн музей – нэг ээлжинд тавин хүн үзэх
 - " Найм дахь гариг " чөлөөт цагын төв - 200 хүний багтаамжтай
 - Цанын бааз – 200 чарга, 100 хос цанатай
 - b) Хөгжөөнт, хөдөлгөөнт тоглоомууд
 - Алсыг харагч, Буухиа элч, эргэдэг сандал, пуужин, гинжит эргүүлэг, агаарын дугуй зэрэг талбайн 14 төрлийн томоохон аттракцион тоглоомоор нэг удаад 3-6 минутад 526 хүнд үйлчилнэ.
 - Бага насны хүүхдэд нархан, морьхон, далайчин, усан аялал, хонхон цэцэг, савлуур, хөгжөөнт зэрэг 1,5 аттракцион тоглоомоор нэг удаад 3-6 минутад 240 хүүхдэд үйлчилнэ.

- 74
- Агаарын болон ширээний теннис, биллярд, Монгол үндэсний хөлөгт тоглоомууд, айдасын агуй, ундаг дугуй, нуурын мандал дээр завиар зугаалах, буудлагын танхимууд, нелестэй толь, теердэг байшин зэрэг 20 – иод терлийн хөгжсөнт тоглоомын цэгээр нэг ээлжиндээ 5- 15 мин 400 – гаад хүүхдэд үйлчилэх боломжтой.
 - Төрөл бүрийн 40 гаруй нэр терлийн автомат болон цахим тоглоомоор нэг удаад 60 хүүхдэд зэрэг үйлчилнэ.
 - c) Худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ
 - "Гоо марал" зоогийг газар - 200 суудалтай
 - Хүүхдийн "Бамбарууш" кофе – 80 суудалтай
 - Хүлээн авалтын танхим – 30 суудалтай
 - Зочны хүндэтгэлийн зоогийн өргөө 12 хүний суудалтай
 - Ундааны автомат үйлдвэр – цагт 2000 лонх ундаа үйлдвэрлэнэ.
 - Морожингийн цех – цагт 1200 ш үйлдвэрлэнэ.
 - Түргэн үйлчилгээний цэг 14, худалдааны үзэсгэлэн яармаг 1 байнга ажиллана.
 - Зочид буудал 15 ортой
 - Уурын банн \бассейн\ -тай - нэг удаад 1-12 хүнд үйлчилнэ.
 - Иж бүрэн тоноглогдсон бие чийрэгжүүлэх танхим, \Японы тоноглолтой \ - нэг ээлжинд 12 хүнд үйлчилнэ.
 - Нийтийн халуун ус – 16 душтэй.
 - Өнгөт болон хар, цагаан фото зургийн үйлчилгээ \морь, тэмээ унуулах зураг авах үйлчилгээ хийнэ\.
 - d) Бусад салбар
 - Талбайн болон тасалгааны, бэлэг дурсгалын зориулалтын амьд цэцгийн үйлчилгээ явуулна.
 - Төрөл бүрийн эрт ургацын ногооны үрслэг, мод үржүүлгээр үйлчилэх ба хамтран ажиллана.
 - Авто сургууль нэг ээлжиндээ 60 хүн элсүүлж жолоочийн мэргэжил олгоно

МҮСАХүрээлэн

ХОЁР. Материаллаг бааз /хүчин чадал/

А. Соёл, спортын цэг нэгжүүд

- Цэнгэлдэх хүрээлэн – 8,0 мянган хүний суудалтай
- Зуны задгай театр – 2,0 мянган хүний суудалтай
- Монгол гэр өргөө - 150 хүний суудалтай
- Үндэсний дуу бүжгийн "Түмэн эх" чуулга – 150 хүний судалтай

Б. Хөгжөөнт хөдөлгөөн тоглоомууд

1. Алсыг харагч, Буухиа элч, Эргэдэг сандал, Пуужин, Уран жолоо, Агаарын дугуй, Агаараас доошлох шүхэр /Бүгд БНХАУ-ын 1991 онд суурилуулсан/ Сюрприз, Гинжит эргүүлэг, /ЗХУ-ын 1966, 1981 онд суурилуулсан/ 9 төрлийн томоохон атракцион тоглоомоор 12-оос дээш насныханд /нэг удаа 3-6 минутад 226 хүнд үйлчилнэ./
2. Бага насны хүүхдэд Морин тойруулга, Нархан, Хонхонцэцэг, /БНХАУ-ын/ Савлуур, Далайчин, Усан аялал, Хөгжөөнт аялал, /ЗХУ-ын/ зэрэг төрлийн атракцион тоглоомоор нэг удаад /3-6 мин/ 128 хүүхдэд үйлчилнэ.
3. Агаарын болон ширээний теннис, билльярд, монгол үндэсний хөлөг тоглоомууд, хүүхдийн качалкууд, айдасын агуй, унадаг дугуй, нуурын мандал дээр завиар зугаалах, буудлагын танхимууд, нелеетэй толь, төөрдөг байр зэрэг 10 гаруй төрлийн хөгжөөнт хөдөлгөөнт тоглоомын цэгээр нэг ээлжиндээ /5-15 мин/ 200-аад хүүхэд үйлчилэх боломжтой юм.

ГУРАВ. Худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ

- "Гоо марал" зоогийн газар – 100 хүний суудалтай
- Зочны хүндэтгэлийн монгол өрөө - 12 хүний суудалтай
- Нийтийн хоолны 4, худалдааны 12 цэгтэй

ДӨРӨВ. Эдийн засгийн нөхцөл, гадаад харилцаа

Тус хүрээлэн нь 1991 он хүртэл улсын дотацаар /санхүүжилтээр/ ажиллаж байсан. 1991 оноос хойш өөрөө өөрийгөө санхүүжүүлэн аж ахуйн тооцоон дээр ажиллаж байна. Энэ хугацаанд 1980 онд улсаас 2,6 сая долларын хөрөнгө оруулалт хийж, БНХАУ-аас 10-аад тоглоом авч суурилуулан нийтдээ 2 удаа техникийн шинэчлэлт хийсэн. Одоогоор бүх тоглоомын ашиглалтын хугацаа дууссан. Гадаад харилцаа хөгжиж чадаагүй, олон улсын Паркын холбооны гишүүн бус байгууллага юм.

21

**ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨВ ПАРКААС
ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН БОЛОН ӨРГӨЖИН ХӨГЖИЖ
ИРСНИЙ ТҮҮХЧИЛСЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Д. Бавуудорж /1965-1999/

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1965 оны 11-р сарын 10-ны өдрийн 333-р тогтоолоор нийслэл Улаанбаатар хотын хүүхэд, залуучуудын дунд улс төр, соёл хүмүүжлийн ажил өргөн зохиож, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж байх зорилгоор хотын соёл амралтын төв паркийг МХЗЭ-ийн Төв Хорооны шууд харьяанд байгуулан, эхний ээлжийг улс хувьсгалын 45 жилийн ойн өмнө тохижуулан ашиглалтад оруулах, холбогдох тоног төхөөрөмжийн ихэнхийг ЗХУ-ын Комсомолын Төв Хороотой харьцаж үнэ төлбөргүй авах, паркийг хүүхэд, залуучууд, хөдөлмөрчдийн амралт зугаалга болон тэд нарын дунд биеийн тамир спорт, соёл хүмүүжил, олон түмний ажил явуулдаг төв болгох арга хэмжээ авахыг МХЗЭ-ийн Төв Хороонд даалгажээ.

МАХН-ын Төв Хорооны дээрх тогтоолыг хэрэгжүүлэхийн тулд соёл амралтын төв паркийг барьж байгуулах ажлыг удирдан зохион байгуулах төв штабыг МХЗЭ-ийн Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нөхөр Пүрэвжаваар удирдуулан байгуулж, паркийн анхны даргаар С. Дашдэндэвийг 1965-1971 он хүртэл томилон ажиллуулжээ.

МХЗЭ-ийн Төв Хорооноос БХЛКЗЭ-ийн Төв Хороонд тавьсан хүсэлтийн дагуу ирүүлсэн мэргэжилтэн, архитекторчдын тусламжтайгаар паркийн ерөнхий зураг төслийг гарган баталж, улмаар паркад хийгдэж тавигдах тоглоом, тоног төхөөрөмж, барилга байгууламж зэрэг нийтдээ 50 орчим нэр төрлийн ажлын зураг төслийг гарган, паркийг байгуулах ажилдаа орсон байна.

Нийслэл хотынхоо төв хэсэгт, урд гэрийн хороолол байсан энэ газарт тус улсын анхны паркийн шавыг тавьж, уулгүй нүцгэн газар ой ургуулж, нуур цөөрөм бий болгон, соёл хүмүүжлийн төрөл бүрийн байгууламж барьж бүтээх нэр их ажил ийнхүү эхэлжээ.

Паркийг барьж байгуулах ажилд МХЗЭ-ийн Төв Хорооны хүсэлт ёсоор БХЛКЗЭ-ийн Төв Хорооны шугамаар анх үеэс нь эхлэн зураг төсөл гаргах, тоглоом тоног төхөөрөмжийг тавьж ашиглалтад оруулах, барилга байгууламжийг барьж дуустал өндөр мэргэжил туршлагатай архитекторч, инженер, мэргэжилтэн, зөвлөхүүдийг ажиллуулахын хамт 1966-1969 онд жил бүр төрөл бүрийн мэргэжлийн ажилчид, оюутнуудыг амралтаар нь /40-өөс 130 гаруй хүнийг ирүүлж/ ажиллуулан тусалцуулжээ.

Тухайлбал архитекторч В. А. Иванов, И. Ф. Отрадинский /1965-1967 он/, барилгын инженер Г. А. Черный /1966-1970 он/, мэргэжилтэн зөвлөх Н. К. Муравьев /1967-1971 он/ нар паркийг барьж байгуулах ажилд ихээхэн үүрэг гүйцэтгэсний дээр хүүхэд залуучуудын "Найрамдал"

Хуучин - 8

паркийг анх байгуулах үед тавигдсан 14 төрлийн тоглоомыг ЗХУ-ын комсомолын байгууллага үнэ төлбөргүй хийж өгчээ.

Түүнчлэн паркийг барьж байгуулах ажилд 1966 оны 03-р сарын 12-ны өдөр Монгол-Зөвлөлтийн 24 залуу эхлэн гарч ажилласан тэр өдрөөс 3 жил гаруй хугацаанд манай оронд ажиллаж байсан Зөвлөлтийн барилгын I, II, III трестүүд, цэргийн ангиуд, манай төрийн яамд, ялангуяа Барилгын Материалын Яам, хотын авто аж ахуйнууд, Ардын Армийн дайчид, нийслэлийн дээд, тусгай дунд сургуулиуд, хот, райодын ХЗЭ-ийн байгууллага, үйлдвэр аж ахуй, соёл гэгээрлийн бүх газруудын ажилчин, албан хаагчид, МХЗЭ-ийн гишүүд, пионер сурагчид өөрсдөө санаачилга гарган субботникийн журмаар ажиллах явдал, бараг бүх нийтийн хөдөлгөөн болж өрнөсөн байна.

Өөрөөр хэлбэл паркийг барьж байгуулахад зөвхөн 1966 онд 70 мянга гаруй хүн өдрийн ажил хийж, 10 шахам сая төгрөгийн барилга, байгууламж барьж босгосны 50 шахам хувийг дан залуучуудын оргилсон хөдөлгөөн, олон нийтийн хүчээр барьсан юм.

Хэрэв паркийг 150 тогтмол ажилчинтай барилга анги барина гэж үзэхэд даруй хоёр бүтэн жил ажиллаж байж барих ажлыг 3 сар гаруй хугацаанд хийсэн байна.

Паркийг байгуулах энэ ажилд МАХН-ын Төв Хороо, манай нам, засгийн удирдагчид байнга анхаарал тавьж, бүтээн байгуулалтын ажилтай нь танилцаж холбогдох арга хэмжээг авч байсны дээр МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн Дарга Ю. Цэдэнбал өөрөө газар дээр нь биечлэн ирж, бүтээн байгуулалтын ажилтай нь байнга танилцан сургамж, зөвлөлгөөн өгдөг байлаа.

Үүний үр дүнд хүүхэд залуучуудын соёл амралтын "Найрамдал" паркийн эхний ээлж ашиглалтад орох болсноор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1966 оны 07-р сарын 04-ний өдрийн 144-р захирамж гарч хүүхэд залуучуудын соёл амралтын паркийг 1966 оны 07-р сарын 10-ны өдөр ардын хувьсгалын 45 жилийн ойн их баярын үеэр нээсэн юм.

Тус паркийн анхны нээлтийн ажиллагаанд Ю. Цэдэнбал тэргүүтэй манай нам засгийн удирдагчид, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга нар, ЗХУ болон БНАГУ-ын дипломат корпусын тэргүүн гишүүд, АХ-ын 45 жилийн ойн баярт оролцохоор ирсэн ЗСБНХУ-ын СнЗ-ийн орлогч дарга М. Т. Ефремов тэргүүтэй ЗСБНХУ-ын нам засгийн төлөөлөгчид, манай АХ-ын партизан, нам төр олон нийтийн зүтгэлтэн, гавъяатууд, манай орны өнцөг булан бүрээс АХ-ын 45 жилийн ойн баяр наадамд ажил үйлсээрээ шалгаран ирсэн төлөөлөгчид, тэргүүний сайчууд, нийслэлийн нам, улс, олон нийт, үйлдвэр, аж ахуй, соёл гэгээрлийн бүх байгууллага, хөдөлмөрчид, МХЗЭ-ийн гишүүд залуучууд, пионер сурагчид, өсвөр үеийнхний төлөөлөгчид, наадамчид өргөнөөр оролцсон давхар баяр болсон юм. Энэхүү баярт үйл явдлыг тохиолдуулан МХЗЭ-ийн Төв Хорооны санаачилгаар Соёл Амралтын Төв Паркийг хүүхэд, залуучуудын "Найрамдал" Парк хэмээн нэрлэх болсон байна.

Хүүхэд залуучуудын "Найрамдал" паркийг 1966 онд нээгээд өргөтгөж, бүтээн байгуулах ажил 1966-1969 онд үргэлжлэн хийгдсэн байна. Энэ ажлыг МХЗЭ-ийн Төв Хорооноос шууд гардан БХЛКЗЭ-ийн Төв Хороо, БНАГУ-ын чөлөөт залуучуудын эвлэлийн байгууллагуудтай

холбоо тогтоон тэндээс төрөл бүрийн инженер техникийн ажилчдыг богино хугацаагаар, оюутан залуучуудын эвлэлийн гишүүдийг зуны амралтын үеэр ирүүлж тоглоом, тоног төхөөрөмжүүдийг байрлуулах гол барилга объектыг байгуулах асар их ажлыг хийжээ.

Тус паркийг 1966 онд анх нээх үед 37 га талбайд 6.0 мянган мод бут, 60 гаруй мянган м² зүлэгжсэн талбай, 2.8 км зам МХЗЭ, пионерийн хүндэтгэлийн талбай, бага оврын морин тойруулга, дүрст тойруулга, алсыг харагч, микропоезд, гинжит тойруулга, пуужин, савлуур, хүүхдийн машин, дугуй, угсаатны зүйн музей, үлгэрийн гэр, кино театр, тунгалаг уст жижиг нуур, завь, Алтанхүү баатар, хүч сорих, мэргэн буудах тоглоом, хийн буудлага, теннис, биллиард, футбол зэрэг 27 цэг, нэгж ашиглалтад орж нээгдсэн байна.

1966 оны 07-р сараас хойш 1969 оны 08-р сарын 30-ны өдөр "Найрамдал" паркийг барьж байгуулах ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх хүртэлх 3 жилийн дотор тус паркад 3000 хүний суудалтай биеийн тамир спортын цэнгэлдэх хүрээлэн, 2000 хүний суудалтай зуны театр, 600 хүний багтаамжтай бүжгийн талбай, нэг удаа 300 хүнд үйлчлэх зоогийн газар, цэцгийн теплиц, аж ахуйн блок, автомат тоглоомын байр, орчин үеийн тоног төхөөрөмж бүхий конторын барилга болон зарим тоглоом зэрэг нийтдээ 30 шахам объект барилга байгууламжууд ашиглалтад орж төрөл бүрийн мэргэжлийн болон үйлчилгээний ажилтан, ажилчидтай болж өргөжсөн байна.

Ингэж хүүхэд, залуучуудын "Найрамдал" паркийн ажиллагаа, үйлчлэх хүрээ тэлж нийслэлийн хөдөлмөрчид, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг боловсон зөв өнгөрүүлэх, амралтын томоохон төв цэцэрлэгт хүрээлэн болж, хот хөдөөгийн хөдөлмөрчид, хүүхэд залуучуудын талархал сайшаалыг хүлээх болсон юм.

Ялангуяа манай оронд уригдан ирсэн гадаадын зочид төлөөлөгчид, түүний дотор ЗХУ болон ах дүү социалист орнуудын нам, төр, олон нийтийн байгууллагын удирдах зүтгэлтнүүд, гадаадын янз бүрийн орноос ирсэн жуулчид Найрамдал паркийн цэцэрлэгт хүрээлэн, цэнгэг агаар, ус нуураар аялан саатан зугаалан амрах ялдамд Монгол Зөвлөлтийн ахан дүүсийн уламжлалт найрамдал, социалист орнуудын залуучуудын эвлэлийн хэлхээ холбоо хэрхэн хөгжиж, хичнээн их зүйл бүтээдгийг бахархан дурсч, баяр талархлаа дэвшүүлэн, дурсгалын мод суулган тарьж үлдээдэг заншилтай болжээ.

Тус паркад 1965-1980 оныг хүртэл гадаад, дотоодын нам, төрийн тэргүүнүүд, Монгол Зөвлөлтийн болон ах дүү социалист орнуудын сансрын нисгэгчид, дэлхийн нэр цуутай урлаг, спортын одод зэрэг 30 гаруй алдартнууд дурсгалын мод тарьж үлдээснийг паркийн хамт олон нандигнан дээдэлж, арчлан ургуулсаар өдий хүргэжээ.

Соёл Амралтын Паркийн нэг үндсэн гол бүрдэл хэсэг болсон ногоон байгууламж нь эх орны нийслэлийн төв хэсэгт, хотын ногоон байгууламжийн 20 гаруй хувийг эзлэн, байгалийн таатай сайхан орчинг бүрдүүлж байна. 1965 оноос хотын паркийн ногоон байгууламжид 26 нэр төрлийн 30.0 гаруй мянган мод, бут тарьж, 3.6 км услалтын системийг тавьж, гүн өрмийн 4 худаг гарган, 16.4 га газрыг зүлэгжүүлж, жил бүр 200-1600 м² талбайд цэцэрлэгжүүлэлт хийж, 500 м² хүлэмж, 0.6 га газрын мод үржүүлгийн болон хүнсний ногооны талбайг эзэмшин ашиглах болжээ.

20

Хөдөлмөрчид хүүхэд залуучуудын дунд улс төр, урлаг спорт, гоо зүй, ёс суртахуун, бие бялдрын өв тэгш хүмүүжил олгох, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилго бүхий соёл амралтын /Найрамдал/ паркийг ийнхүү барьж байгуулсан нь МАХН, засгаас өсвөрийн залуу үеийн төлөө ямар их анхаарал халамж тавьж байдгийн яруу тод илрэл, МХЗЭ хэзээнээс нааш шинэ юмыг сэдэн санаачилж, бүтээн буй болгоход эх оронч үйлсийн тэргүүн эгнээнд явж ирсний бахархалтай жишээ юм.

"Найрамдал" парк нь 1966-1978 онд жилдээ 69.9-176.7 мянган төгрөгийн орлого оруулж, байгаа материаллаг баазынхаа төвшинд хэвийн ажиллаж байсан боловч, тоглоом тоног төхөөрөмж нь хуучирч, материаллаг бааз нь муу ашиглагдаж, олон нийтийн дунд зохиогдох ажлын арга хэлбэр далайц, хоцорч, орлого үйлчилгээний төлөвлөгөөг 1976-1979 онд 15-37 хувиар тасалдуулж үйл ажиллагаа нь доголдож ирсэн учир МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо /Анастасия Ивановна Цэдэнбал-Филатовагийн идэвхтэй оролцоотойгоор/ паркийн тухай асуудлыг тусгайлан авч хэлэлцээд, 1979 оны 7-р сарын 14-нд "Хүүхэд Залуучуудын Найрамдал паркын ажлыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 278-р тогтоол гарч Хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас /1975-1979 онд Хотын Захиргааны харьяанд байсан/ МХЗЭ-ийн Төв Хороонд буцааж харьяалуулсан нь паркийн шинэчлэл өөрчлөлтөд шинэ үе болсон юм. Уг тогтоолд паркийн ажилд тал бүрийн тусламж дэмжлэг үзүүлж, тоног төхөөрөмжийг гадаадаас захиалан ирүүлж өргөтгөх, шинэчлэн төхөөрөмжлөх, материаллаг баазыг бэхжүүлэх, паркад зохиогдох соёл хүмүүжил, урлаг спортын үр нөлөө бүхий ажлыг хамтран зохион байгуулж хэвшүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулахыг холбогдох яам, улсын хороо, олон нийтийн төв байгууллага, нийслэлийн нам, улс олон нийт соёлын байгууллагад даалгасан юм. Түүнчлэн МАХН-ын Төв Хорооны Ерөнхий Нарийн Бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн дарга н.Цэдэнбал, Намын Төв Хорооны УТТ-ны гишүүд, нарийн бичгийн дарга нар, МХЗЭ-ийн Төв Хорооны нарийн бичгийн дарга нар, Хүүхдийн Төлөө Хөгжлийн Төв Комиссын дарга А.Н.Цэдэнбал-Филатова болон манай нам төрийн удирдах зүтгэлтнүүд тус паркийн ажилтай байнга танилцаж, зүйл бүрээр туслан дэмжиж анхаарал халамж байнга тавьж ирснийг дурсан тэмдэглэх ёстой.

МХЗЭ-ийн Төв Хороо Хотын Намын Хороотой хамтран Намын Төв Хорооны тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг эрхлэн зохион байгуулах штабыг өргөн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж /паркийн даргаар н.Д.Бавуудоржийг томилжээ/ холбогдох яамд, тусгай газрууд, Хотын Нам Улс Төр ОНБ-уудтай нягт хамтран ажилласны үр дүнд паркийн материаллаг баазын бэхжилт, үйл ажиллагааны цар хүрээнд үндсэн өөрчлөлт гарсан юм.

Тухайлбал: 1979 оны намраас 1.8 га талбай бүхий том нуурыг барьж байгуулах ажилд орж 1980 онд ашиглалтад оруулсны дээр, улсын хөрөнгө оруулалтаар 1981-1983 онд ЗХУ-аас захиалан шинээр Алсыг харагч, Сюрприз, Уран жолоодлогын машинууд, Гэрлэн дохиот микроавтобус, Хөгжөөнт аяллын галт тэрэг, хүүхдэд зориулсан Алсыг харагч, Далайчин зэрэг 1240.0 мянган төгрөгний үнэтэй 7 төрлийн том талбайн аттракцион, 129.3 мянган төгрөгийн үнэ бүхий том хүний

25

зориулалттай 16, хүүхдийн зориулалттай 8 бүгд 24 төрлийн автомат тоглоомыг ЗХУ-аас худалдан авч ашиглалтанд оруулж, хөдөлмөрчид, хүүхэд залуучуудад үйлчилдэг болов.

Паркийн захиргаа тоглоом, тоноглолоо өргөтгөн шинэчлэх талаар идэвхтэй ажилласны үр дүнд 1989-1990 онд БНХАУ-аас хилийн худалдаагаар Буухиа элч, Пуужин, Эргэлддэг сандал, Агаараас доошлох шүхэр, Агаарын дугуй, Морин тойруулга зэрэг хөдөлгүүртэй 8, орчин үеийн хийцтэй 30 ширхэг цахим тоглоомыг худалдан авч, угсран ашиглалтад оруулсны дээр инженер техникийн ажилтнуудын санаачилгаар 1986, 1988 онд Усан аялал, Айдсын агуй зэрэг Монголын үндэсний анхны цахилгаан хөдөлгүүрт тоглоомуудыг шинээр хийж ашиглалтанд оруулсан болно. Мөн 1996 онд Уран жолоодлого, 1998 онд Сармагчин, Атгадаг гар, 100 мангас зэрэг тоглоомуудыг худалдан авч ашиглалтанд оруулжээ.

Тус паркийн хамт олон 20 жилийн ойгоо угтаж Зөвхөн 1985-1986 онд Үлэг гүрвэл, Үлгэрчин өвгөн, Цэцэн хүү, Долоон хожгор нэг можгор, Ишиг ба чоно, Карлсон, Алтан загасны үлгэр зэрэг 36 тооны үзмэр, баримал, сийлбэрийн зүйл багтаасан Ардын үлгэрийн хотхоныг шинээр байгуулан, МАХН-ын XIX Их Хурлын өмнө ашиглалтанд оруулжээ. 1985 онд Усан оргилуурыг шинээр барьж, Спорт блокийн дотоод төхөөрөмжийг шинэчлэн, уурын халуун устай болгож, Төөрөх байрны гадна ханыг "Дэлхийн үлгэрийн хотууд" сэдэвт шавар хээгээр чимэглүүлж, гайхамшгийн хананд бүрэн шигтгээ хийлгэн, завины станцын бетонон шат болон барилга байгууламжуудын засвар тохижилт, зам талбайг өргөтгөн шинэчлэхэд жил бүр 1.2-3.8 сая төгрөгийн төсөвт ажил хийж иржээ.

1987 онд БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол гаргуулан "Туяа" кафег тус байгууллагын харьяанд авч хөдөлмөрчдийн соёл амралтын үйлчилгээний иж бүрэн цогцолбор байгуулж тохижуулан "Туяа" кафег түшиглүүлэн "Чөлөөт цагийн 8 дахь гараг" диско клуб байгуулан, төрөл бүрийн шинэ хэлбэрийн ажил зохион явуулдаг болсны дээр паркаа үндэсний парк болгон өөрчлөн тохижуулах зорилгоор 1986 оноос урлал чимэглэлийн мастерын газар шинээр байгуулж, байгууллагаа үлгэр жишээ соёлжуулан тохижуулах ажил хийж энэ хугацаанд хашааны баруун ба төв хаалга, ардын язгуур урлагийн "Түмэн эх" чуулгын байр, "Хотол баясгалант" харш, гадаадын аялагч жуулчдыг хүлээн авч үйлчлэх өрөө, дэлгүүр, монгол үндэсний иж бүрэн тоног төхөөрөмжтэй сийлбэр-гоёл чимэглэлтэй гэр, цэцгийн хүлэмж, автомат тоглоомын төвийг шинээр барьж байгуулан ашиглалтад оруулжээ.

Паркийн захиргаа байгаа материаллаг бааздаа тулгуурлан хөдөлмөрчид, хүүхэд залуучуудын дунд үр нөлөө бүхий сонирхолтой олон хэлбэрийн ажлыг зохиож, уламжлал болгох талаар ихээхэн анхаарч иржээ. Ялангуяа 1979 онд гарсан улс төрийн Товчооны 278-р тогтоолыг хэрэгжүүлэх үндсэн дээр хүүхэд залуучуудын "Найрамдал" паркад зохиогдох соёл, олон түмний ажлыг удирдан зохион байгуулах хотын штабыг Улаанбаатар хотын Намын Хороон дээр байгуулж, зун цагт зохиогдох бүх нийтийг хамарсан арга хэмжээний календарчилсан төлөвлөгөөг /7 хоног бүрээр/ батлан мөрдүүлж, уг ажилд Яам тусгай газрууд, уран бүтээлийн эвлэл холбоод, олон нийтийн байгууллагууд, хот дүүргүүдийг татан оролцуулдаг болсноор олон түмний дунд зохиогдох

ажилд үндсэн өөрчлөлт гарсан байна. Энэ ажлын явцад яам тусгай газар, агентлаг, дүүргүүдийн өдөрлөгүүд, бага наадмууд, спартакиадууд, үзэсгэлэн сурталчилгаа, түүхт ойнуудыг тэмдэглэх ажил тогтмолжин, "Найргийн даага", "Найман сайхан ээж", инээдмийн баяр, хүүхэлдэйн урлагийн наадам, "Улаан цэцэг" улс төрийн дууны наадам, "Их сорилго" ардын засгийн жилүүдийн аваргуудын нэрэмжит барилдаан, сургууль төгсөгчдийн баяр зэрэг 40 гаруй сэдэвт ажлууд уламжлал болон зохиогдож хэвшсэн байлаа. Паркад явагдах соёл хүмүүжлийн ажлыг улс төр, ёс суртахуун, гоо зүй, хөдөлмөр, цэрэг эх оронч, бие бялдар хөдөлмөрийн хүмүүжил олох зэрэг чиглэлээр явуулж жилд дунджаар 80-170 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 36-340 орчим мянган хүнд, тоглоомын үйлчилгээгээр 660.0-1.2 сая хүнд үйлчилгээ үзүүлж иржээ.

1987 оноос эхлэн тус байгууллагын дэргэд ардын язгуур урлагийн "Түмэн эх" чуулга байгуулж, мэргэжлийн жүжигчидтэй болж, 1988 оноос эхлэн аймаг орон нутгаар, 1989 нд БНХАУ-д явж тоглолт хийсэн бол Англи дахь Төвд Монголын Соёлын төвтэй байгуулсан 5 жилийн гэрээний дагуу 1991 оноос Испани, Ирланд, Шотланд, Япон, Өмнөд ба хойд Солонгос, Оросын Холбооны Улс зэрэг 20-иод оронд явж амжилттай тоглон өөрийн орны уламжлалт урлаг, дуу хуур, хөөмий, цам бүжгээ сурталчилж байгаа нь тэдгээр орны үзэгчдээс өндөр үнэлэлт авч байгаа төдийгүй олон улсын уралдаанаас 6 удаа хүндтэй шагнал авч, өөрийн улсын ба хотын чанартай уралдаан, тэмцээнээс 13 удаагийн шагнал хүртээд байна. "Түмэн эх" чуулгын уран бүтээлийн сан хөмрөг ихээхэн арвижиж, уран бүтээлчдийн ур чадвар, мэргэжлийн түвшинд бодитой өөрчлөлт гарсны үр дүнд Соёлын Яамны аттестатчилаар "Мэргэжлийн урлагийн байгууллага" гэдэг гэрчилгээг авч ардынхаа урлагийн баялаг өв санг гадаад, дотоодод сурталчлах үйл хэрэгт өөрийн гэсэн байр сууриа нэгэнт эзэлж чадсан юм. Тус чуулгын хамт олноос энэ богино хугацаанд Улсын Гавъяат Жүжигчин 1, Монгол Улсын Соёлын Тэргүүний Ажилтан 11, "Гоо марал" шагналтан 3, улсын уралдааны тэргүүн шагналтнууд 20-иод төрөөд байна.

"Найрамдал" паркийн дотор 1990-ээд оны үед ардын үндэсний хэв шинж бүхий барилга байгууламжууд, цэг нэгжүүд, зарим нэгэн цогцолборууд буй болсон төдийгүй үйлчилгээ, урлаг спортын төвүүд байгуулагдаж үйл ажиллагаа нь монгол ардынхаа өв уламжлал, зан заншил, ёс зүй, урлаг соёл руугаа зонхилон чиглэгдэх болсонтой холбогдуулан удирдах байгууллагадаа танилцуулсны дагуу 1991 оноос "Монголын Үндэсний соёл Амралтын Хүрээлэн" гэдэг нэртэй болсон байна.

Үндэсний Соёл Амралтын Хүрээлэнгийн хамт олон байгуулагдсанаас хойших 32 жилийн 21 жилд нь төлөвлөгөөгөө биелүүлж, 11 жилд нь /1973-1978, 1991, 1995, 1996-1998 онуудад/ тасалдуулж 1992 оноос улсаас нэг ч төгрөгийн төгрөгийн дотац авахгүйгээр орлогоороо зарлагаа нөхөж, бие даан аж ахуйн үйл ажиллагаагаа явуулан 4.3-26.0 сая төгрөгийн ашигтай ажмиллаж иржээ. Хүрээлэнгийн захиргаа хамт олны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажилтан ажилчдыг мэргэшүүлэхэд байнга анхаарч оны манлай хамт олон, хэсэг нэгж, ажил мэргэжлийн аваргаа шалгаруулж, урамшилт цалингийн систем тогтоосны дээр жил бүр нийт аижлагсдын үндсэн

цалингаа 20-25%-иар тогтмол нэмэгдүүлж, өдрийн хоол, түлээ нүүрсний зохих хөнгөлөлтүүдийг олгодог болсон байна.

ҮСАХ нь одоо 1.5 миллиард төгрөгийн үндсэн, 107.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, соёл хүмүүжлийн ажлын 6 объект, тоглоомын 26 цэг, аж ахуй болон ахуй үйлчилгээний 8 нэгж, худалдаа үйлчилгээний 20 гаруй цэгтэй, нийтдээ 60 гаруй цэг дээр 4-12 сараар ажил үйлчилгээ явуулж жилд 1.2-1.6 сая хүнд үйлчлэн, дунджаар 210-300.0 орчим сая төгрөгийн үйлчилгээ явуулж байна.

Хүрээлэнгийн хөдөлмөрийн хамт олон байгуулагдсанаасаа хойш системийн байгууллагуудынхаа хэмжээнд тэргүүн байруудад 18 удаа шалгарч 1984 онд Сүхбаатарын районы "Соёлч Тэргүүний Байгууллага", 1985 онд МХЗЭ-ийн Төв Хорооны "Залуу гавшгайч", 1986 онд МХЗЭ-ийн Төв Хорооны "Тэргүүний Ажилчин Залуу" алтан медальт хамт олон болж, 1988, 1989 онуудад бүх ард түмний социалист уралдаанд 2 удаа шалгарч, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын СнЗ, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн шилжин явах улаан туг, диплом мөнгөн шагналаар шагнуулж, YII, YIII таван жилийн гавшгайч хамт олон болсон байна. Манай хамт олны дотроос дуучин Үенч УГЖ, уртын дуучин Базарбат Хөдөлмөрийн Гавъяаны Улаан Тугийн Одонгоор, Ц. Пүрэвхүү, С. Батнасан, У. Чулуунцэцэг, Б. Түвшинбаяр, инженер Ж. Мягмар, кассчин А. Нямаа, автоматын инженер Ш. Санхүү нар Алтан Гадас одонгоор, С. Гомбосүрэн, хотхоны ахлагч Д. Цэрэнхишигт нар Хөдөлмөрийн Хүндэт Медалиар, механик А. Гэндэнжамц, слесарь Д. Цагаан, харуул Г. Мөнгөнхуяг нарын 40 гаруй хүн АХ-ын ойн медалиудаар, /шагнагдагсдын жагсалтыг хавсаргав./ МХЗЭ-ийн нэгдүгээр нарийн бичгийн дарга асан Ч. Пүрэвжав, паркийн дарга асан С. Лунаа, слесарь Д. Цагаан, механикч А. Гэндэнжамц нар ҮСАХ-ийн Хүндэт Тэмдгээр тус тус шагнагдсаны дээр 160 гаруй хүн МХЗЭ-ийн Төв хорооны хүндэт шагналуудаар, 40 гаруй хүн YI, YII, YIII таван жилийн гавшгайчаар шагнагдаж 36 хүн гадаад, 51 хүн дотоодод аялан жуулчилжээ.

ҮСАХ-ийн захиргаа хүрээлэнгийн ойрын болон хэтийн бодлого зорилгыг тодорхойлох шаардлагыг үндэслэн "ҮСАХ-2010" нэгдсэн хөтөлбөрийг боловсруулан мөрдөж байна.

Энэ ажлын хүрээнд доорх үндсэн 3 зорилтыг тодорхойлох шаардлагыг үндэслэн "ҮСАХ-2010" нэгдсэн хөтөлбөрийг боловсруулан мөрдөж байна.

1. Хүмүүсийн сэтгэхүйд он удаан жил хоногшсон "Хүүхдийн парк" гэсэн хэвшмэл ойлголтыг өөрчлөн үр хүүхэд, эцэг эхчүүд бүгдээрээ хамт зугаацан саатаж чөлөөт цагаа өнгөрөөдөг боломж бүхий "Чөлөөт цагийн төв" болгох.
2. Хүрээлэнгийн үйл ажиллагааны улирлын шинж чанарыг өөрчлөн жилийн 4 улиралд байнгын ажилтай байх эдийн засаг, материаллаг нөхцөл, үйлчилгээний тогтсон системтэй болох.
3. Техник технологийн хувьд шат дараалалтай шинэчлэл хийж, ямар ч хөрөнгө оруулалт хийгдэх дэд бүтцийн болон орчны таатай нөхцлийг бүрдүүлэх

Эдгээр 3 зорилтын 1-р шат нь 2005 он буюу нийслэл хот байгуулагдсаны 365 жил, парк байгуулагдсаны 40 жилийн ойн өмнө, 2-р үе шат нь хөтөлбөр хэрэгжиж дуусах таван жилийн хугацаанд хэрэгжүүлснээр монголын үндэсний ганц парк Соёл

Амралтын Хүрээлэнг өөрийнхөө оноосон нэр "Happiness land" буюу аз жаргалын орд нэрэндээ тохирсон үйл ажиллагаа явуулж чаддаг болгох, улмаар олон улсын паркуудын жишигт хүргэх эхний алхмыг хийх явдал юм.

/Паркийн түүхчилсэн танилцуулгатай холбогдсон зарим материал, жагсаалт, онцлог үйл явдлыг товчлон хавсаргав./

ТҮҮХЧИЛСЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГЫГ:

БЭЛТГЭСЭН
ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

Д. БАВУУДОРЖ
Р. ЗОРИГТ